

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
7 ДУГААР САРЫН ТАЙЛАН

2022.07.22

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН БОДЛОГО

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: 7 дугаар сарын байдлаар Тамгын газраас 971 бичиг явж, 253 бичиг ирсэн байна.

Албан бичгийг удирдлагад танилцуулан цохолт хийлгэж холбогдох мэргэжилтэнд бүртгэлээр хүлээлгэн өгч, хариу барагдуулан эргэх холбоотой ажиллалаа.

Хариутай 371 албан бичиг ирсэн. Хугацаатай албан бичгийн барагдуулалт 100% байна.

Тайлант сард багийн Засаг даргын албан тодорхойлолтыг 2328 иргэнд гаргаж үйлчилсэн байна.

Сумын Засаг даргын “А”захирамж-229, “Б” захирамж-16, Тамгын газрын даргын “А” тушаал-118 “Б” тушаал-77 гарсан байна.

Байгууллагын архиваас нийт 65 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн.

Баруун-Урт сумын "Төрийн үйлчилгээний оператор" нь 22 төрлийн лавлагааг 917 иргэнд гарган үйлчилсэн.

Байгууллагын мэдээллийн цагийг 24 удаа зохион байгуулан тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг албажуулж ажилласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын ИТХуралд Тамгын газрын хагас жилийн тайланг танилцуулсан.

Сумын Засаг даргын “А”захирамж-229, “Б” захирамж-16, Тамгын газрын даргын “А” тушаал-118 “Б” тушаал-77 хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчлийг арилган ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж 1044 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч, хариу мэдээлж, эргэх холбоотой ажилласан. Өргөдөл, гомдлын барагдуулалт 97%-тай байна. Өргөдөл, гомдлын улирлын тайланг гарган аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд хүргүүлсэн.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО:

Спортын чиглэлээр: “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийн хүрээнд Баруун-Урт хотын аварга шалгаруулах МАРАФОН-2022 гүйлтийн тэмцээнийг аймгийн БТСГазартай хамтран гурван насны ангилалд зохион байгууллаа.Тэмцээн 2022 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж 12 байгууллага, 2 сумын 18 нас хүртэл 85хүүхэд, 19-29 насны 12 , 30 дээш насны 12 тамирчин тус тус оролцлоо.Үүнд:

18 хүртэлх нас эрэгтэй:

1- байр О.Чингүүн

2-байр Б.Батхолбоо

3-р байр Ө.Тэмүүлэн

18 хүртэлх нас эмэгтэй:

1-р байр Ё.Мөнхжин

2-р байр Мөнхзул

3-р байр Мөнхнамар

19-29 насны ангилалд:

1-р байр Н.Батжаргал ОЕГ

2-р байр А.Нямбаяр Цайрт минерал

3-байр Б.Бямбасүрэн Эрдэнэцагаан сум

Тусгай байр С.Ариунболд

30-аас дээш эрэгтэй:

1-р байр Ч.Сэргэлэн 338-р анги

2-р байр Ц.Өсөхбаяр БТСГазар

3-р байр Э.Далантай ПБЭХС-ийн Сүхбаатар дахь салбар

30-аас дээш эмэгтэй:

1-р байр М.Мөнхдэлгэр ОБГазар

2-р байр М.Мөнхцэцэг ОБГазар

3-р байр Д.Энх-Отгон БТСГазар

Тэмцээнд оролцсон нийт тамирчдадаа баяр хүргэе.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа шинээр тогтоолгох 8, асаргаа сунгах 31, асран хамгаалагч солих 1, хорих ангиас суллагдсан 1 иргэн, гал түймрийн улмаас орон гэргүй болсон 1 нийт 2 иргэнд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжинд хамруулахаар тус тус хэлэлцсэн.

Шинэ төрсөн хүүхэд-41, цалинтай эхийн тэтгэмжинд-59, жирэмсэн эхийн тэтгэмжинд-55, ихэр хүүхдийн тэтгэмж-1, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт шинээр орж байгаа болон сунгагдсан-21, нийгмийн даатгалаас нас барсны тэтгэмж авах эрх үүсээгүй 2 иргэнийг тус тус бүртгэн нөхөн олголтыг бүрэн хийж гүйцэтгэлээ.

Мөн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу хөнгөлөлт тусламжинд хамрагдах иргэдийн хувийн хэрэг материалыг хүлээн авч баталгаажуулан бүрэн хамрууллаа. Үүнд:

- Ахмад настан-58
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн-3

2022 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахим хуралд хамрагдсан.

Малжуулах арга хэмжээний хүрээнд Баруун-Урт сумын 8 өрхөд профайлинг үйлчилгээг хийсэн.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд Баруун-Урт сумын 2, 4, 6-р багийн Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг өрхийн ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа 15 иргэнийг хамруулсан. Мөн бичиг баримтаа хаясан, захиалж чадахгүй байгаа 4 иргэн, оёдлын сургалтанд хамрагдах 7 иргэн, нийтийг хамарсан ажилд ажиллах 3 иргэний судалгааг гарган холбогдох мэргэжилтэнд өгсөн.

КАМ-ын шалгуур хангаагүй иргэдийн мэдээллийг тухай бүр засаж байна.

Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 7 дугаар сарын 25-ны байдлаар

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	393	113789988
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	483	64573088
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	2	2400000
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	58	10579400
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	3	454550
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	224	7848331
7	Хүүхэд асарсны тэтгэмжинд	1031	51246845
8	Оршуулга	2	2000000
9	Ихэр хүүхэд	1	2000000

Улсын бүртгэлийн чиглэлээр:Төрсний бүртгэл-311, гэрлэлт-46, Иргэний үнэмлэхний хугацаа дуусч авсан-337, шинээр олгосон иргэний үнэмлэх-250, Аймаг, хотоос шилжин ирсэн-156, хот доторх шилжилт хөдөлгөөн-481, сум дүүрэгт шилжин ирсэн-160, гэрлэлт цуцлалт-13, Үрчлэлт-9, эх, эцэг тогтоосон бүртгэл-12, овог нэр өөрчилсөн-118, нас баралт-76, улсын бүртгэлтэй холбоотой 940 лавлагаа тус тус гарган өгч үйлчилсэн.

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО:

Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, 8 багийн айл өрхүүдэд аймгийн Засаг даргын албан даалгаврыг танилцуулан хугацаатай албан тоот хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажилласан.



Аймгийн төвд малтай байгаа 4 өрхөд мэдэгдэл хүргүүлэн тогтоосон хугацаанд 120 мал гаргасан. Мөн аймгийн төвд орж ирсэн малын мэдээллийг 99899487 утсаар тогтмол хүлээн авч, нийтийн эзэмшлийн зам талбайгаас хөөн гаргаж байна.



Багийн ажлын албатай хамтран 9 багийн айл өрхүүдээр явж унасан хашаа болон нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдал, овоолго шороо, мэдээллийн самбар зэргийн эзэн холбогдогчийг тогтоон мэдэгдэл өгч, засварлуулж байна.



Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор үерийн ус зайлуулах далан сувгийн хог хаягдлыг цэвэрлүүлсэн. Нийт 1 тонн хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.



дээр нь очиж танилцсан.

2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн шөнө орсон усархаг борооны улмаас 2, 3, 5, 7 дугаар багийн айлын өрх усанд автсан Газар



2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 16 цаг орчимд орсон борооны улмаас нийт 8 айл усанд автсан. Ерөнхий зориулалттай шуурхай командын бие бүрэлдэхүүн ажилласан.



2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 16 цаг орчимд орсон борооны улмаас 1,2,5,7,9 багийн айл өрхүүд усанд автсан. Нийт 8 айлыг нүүлгэн шилжүүлсэн.



Сүхбаатар Ойжуулалт сум дундын ойн ангийн эзэмшлийн модыг Баруун-Урт Цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.

Ажлын хэсэгт:

1. Аймгийн Байгаль орчин аялал жуучлалын газрын мэргэжилтэн н.Борчулуун
2. Баруун-Урт сумын Байгаль орчин, аялал жуучлал хариуцсан мэргэжилтэн Г.Лэгжиймаа
3. Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ-ын инженер Н.Балдандорж
4. Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ-ын нябо н. Энхтөр
5. Сүхбаатар Ойжуулалт сум дундын анги ОНӨААТҮГ-ын нябо н.Номин-Эрдэнэ

Нийт 7 төрлийн 8000 гаруй модыг тоолон хүлээлгэн өгсөн. Эдгээрх моднуудад мониторинг хийсэн бөгөөд 85%-ийн ургалттай тооллого хийгдсэн болно.



Нийтийн эзэмшлийн зам талбайд хөл газрын ургамлын тархац ихэссэнтэй холбогдуулан Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний газарт бүртгэлтэй, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 20 иргэнийг түр ажлын байраар ханган дараах газруудын хөл газрын ургамлууд түүж цэвэрлүүлсэн.Үүнд:

- Анхилам халуун усны газраас Байшинт ойл ШТС хүртэл
- Цагдаагийн газрын ар талаар
- Төмөртэйн хойд хэсгээр
- Цагдаагийн газрын урд талын баруун 4 замаас баруун пост хүртэл

- Дөрвөлж толгой

Нийт 1000м² талбай, 40 тонн хөл газрын ургамлыг түүн, төвлөрсөн хог хаягдлын цэгт зөөж тээвэрлэсэн.

Мөн Төмөртэй зам дагуух, Хайлааст үүдэн буюу шинэ наадмын талбайн зүүн хойд талд үерийн усны улмаас үүссэн эзэнгүй хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Нийт 8 тонн хог хаягдлыг төвлөрсөн хог хаягдлын цэгт зөөж тээвэрлэсэн.



Баруун-Урт сумын хэмжээнд нийт 28 золбин нохой устгасан.



2,7 дугаар багуудын нутаг дэвсгэрт орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар тендэрт “Хүрэл-Соёмбо” ХХК шалгарч бялдаржуулах талбай болон явган зам, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Одоогоор ажлын явц 60%-тай байна.

Сүхбаатар аймаг байгуулагдсан 80 жилийн ойн хүрээнд Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Үдэлт угталтын хаалгыг засварлах, шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Ажлын явц 80%-тай байна.



Сүхбаатар аймаг байгуулагдсан 80 жилийн ойн хүрээнд тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа явуулах 100 гэрийн болон худалдаа үйлчилгээ явуулах газруудын байршлын хэмжээ талбай, транс тавих ажлыг хийж гүйцэтгэсэн.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20 сая төгрөгийн төсөв өртөгтэй 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах, ЗХ-ний 168-р ангийн урд талын 11 айлын хашааг шинэчилж, евро хашаажуулах ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгүүлж байна. Мөн 6-р багийн нутаг дэвсгэрт байрлах, барилгачдын талбайг тохижуулах ажлыг гэрээний дагуу “Тойргийн тэгшитгэл ХХК” хийж гүйцэтгүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

80 жилийн ойг угтан сумын хэмжээнд хог болон хөл газрын ургамлын их цэвэрлэгээг 2022 оны 07 дугаар сарын 18-наас 25-ны хооронд зохион байгууллаа. Нийт 83 байгууллагад албан тоот хүргүүлснээс их цэвэрлэгээнд бүрэн хамрагдсан 48, дутуу цэвэрлэгээ хийсэн 30, огт цэвэрлэгээ хийгээгүй 5 байгууллага байна.

ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНД БҮРЭН ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГУУД

1. Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар
2. Онцгой байдлын газар
3. Баруун-Урт сумын ЗДТГ
4. Аймгийн Нэгдсэн Эмнэлэг
5. Эрүүл мэндийн газар
6. Өрхийн эмнэлэгүүд
7. Орон нутгийн өмчийн алба
8. Дөрвөлж ОНӨҮГ
9. Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК Сүхбаатар аймаг
10. Байгаль орчин аялал жуучлалын газар
11. Насан туршийн боловсрол
12. 1-р сургууль
13. Татварын хэлтэс
14. Боловсрол өргөө дотуур байр
15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
16. Нийгмийн даатгалын хэлтэс
17. Монгол банк
18. Стандарт хэмжилзүйн хэлтэс
19. Биеийн тамир спортын газар
20. Сүхбаатар Нийтлэг Үйлчилгээ ОНӨҮГ
21. Боловсрол шинжлэх ухааны газар
22. Улсын бүртгэлийн хэлтэс
23. ГБХЗХГ
24. Шүүх шинжилгээний алба
25. Нийтийн номын сан
26. Аймгийн мал эмнэлэг
27. Хаан банк
28. Хас банк
29. Магнай Трейд ХХК
30. Жаст ойл ХХК
31. Байшинт ойл ХХК
32. Наран ХХК

33. Баруун-Урт Цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ
34. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
35. Прокурорын газар
36. 9-р цэцэрлэг
37. 1-р цэцэрлэг
38. 3-р цэцэрлэг
39. 4-р цэцэрлэг
40. 5-р цэцэрлэг
41. 6-р цэцэрлэг
42. 10-р цэцэрлэг
43. 11-р цэцэрлэг
44. Уртын гэгээ ОНӨААТҮГ
45. Сүхбаатар Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ
46. МСҮТ Сүхбаатар аймаг дахь салбар
47. Сүхбаатар аймгийн сум дундын шүүх
48. Тотал дистрибшин ХХК

ХУВААРЬТ ГАЗРАА ДУТУУ ЦЭВЭРЛЭСЭН БАЙГУУЛЛАГУУД

1. Тагнуул
2. Төрийн банк
3. Цахилгаан холбоо
4. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
5. Аймгийн ЗДТГ
6. Мэргэжлийн хяналтын газар
7. Санхүү хяналт аудитын алба
8. Шуудан холбоо
9. ЗХ-ний 168-р анги
10. ЗХ-ний 338-р анги
11. Угсаатны зүй музей
12. Хүнс хөдөө аж ахуйн газар
13. Голомт банк
14. Статистикийн хэлтэс
15. Тээвэр авто замын газар
16. Нисэх буудал
17. Талын зам ТӨҮГ
18. Сүхбаатар Ойжуулалт сум дундын ойн анги ОНӨААТҮГ
19. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК
20. 2-р сургууль
21. 3-р сургууль
22. 4-р сургууль
23. 2-р цэцэрлэг
24. 7-р цэцэрлэг
25. 8-р цэцэрлэг

26. Петровис ХХК
27. Шунхлай ХХК
28. Сод Монгол ХХК
29. Тэс петролиум ХХК
30. Цайрт минерал ХХК

ХУВААРЬТ ГАЗРАА ЦЭВЭРЛЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГУУД

1. Сүхбаатар аймаг дахь Аудитын газар
2. Эрдэнэ мандал хийд
3. Жаахан шарга театр
4. Цаг уур орчны шинжилгээний төв
5. Баруун-Урт ИТХ

2022 оны 07 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Баруун-Урт сумын 9 багийн иргэдийг бүх нийтийн цэвэрлэгээнд хамруулж, баг тус бүр дээр 2 машин, 4 ачигч, Тамгын газрын нийт албан хаагчид ажиллаж, 50 тонн хөл газрын ургамлыг төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөж тээвэрлэсэн.



ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО:

Мал эмнэлгийн чиглэлээр: Мал эмнэлгийн ерөнхий газраас үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор онлайн асуумж судалгааг 6-н мал эмнэлэг, 60 малчин өрхөөс авсан. Уг асуумжийн хүрээнд Баруун-Урт сумын 8-р багийн 2 өрхөд үхрийн арьс товруутах өвчний шинж тэмдэг илэрсэн тул ажлын хэсэг гарч зам дагуу айл өрхийн үхэрт үзлэг тандалтын ажил хийсэн. 8-р багийн иргэн Д.Амгаланбаатарын үхэрт үхрийн арьс товруутах өвчний сэжиг бүхий үхэр байсан тул тус үхрээс дээж авч, шинжилгээг УМЭАЦТЛ-д хүргүүлж, хариу сөрөг гарсан.

Мал эмнэлгийн цахим нэгдсэн системд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, боловсруулалт, туулгалтыг төлөвлөлтийг оруулсан.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор угаалганд 6000 мянган бог мал угаасан.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал